



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/94

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 сарын 16 ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Шинэ хөдөө-Хөвсгөл" төслийн хүрээнд Тариалан суманд хэрэгжиж байгаа Сэлэнгэ үүлдрийн үхрийн цөм сүрэгт шаардлагатай өвс тээвэрлэж хүргэх зардалд 1,004,100 (Нэг сая дөрвөн мянга нэг зуун) төгрөг, малын сувилалын эм тарианд 686,500 (Зургаан зуун наян зургаан мянга таван зуун) төгрөг, нийт 1.690.600 (Нэг сая зургаан зуун ерөн мянга зургаан зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1,690,600 (Нэг сая зургаан зуун ерөн мянга зургаан зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН